

Герман – ард түмний улс

*ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ажилтан Л. Бэгзжав*

Монголоор Герман улс гэж дууддаг нь угтаа латин хэлний Germania гэсэн үгнээс дуудлага хувиран үүссэн юм. Герман хэлний Deutschland буюу Дойчланд гэдэг нь эртний герман хэлэнд “ард түмний улс”, “ард түмний газар нутаг” гэсэн утгатай: Гэвч Европын орнуудаас Голландаас бусад нь Дойчланд гэж нэрлэдэггүй. Тухайлбал англичууд эртний Ромын эзэнт улсын үеийнхээр “Germany” гэж нэрлэдэг нь герман үндэстний оршин суудаг газрыг заасан үг аж. Франц улс III зууны Германы нэг овог аймгийн нэрээр Арэман гэж нэрлэдэг. Европын улсууд ч мөн Германыг өөр өөрөөр нэрлэдэг ба Европт хамгийн олон нэртэй улс бол Герман аж.

МЭ 843 онд Франкын эзэнт улс мөхсөний дараа Шваб, Бавари зэрэг овгийнхон нэгдэж Дорнод Франкын хаант улс бий болсоноор Герман улс бүрэлдэн тогтсон юм. МЭ 962 онд герман үндэстэн ариун Ромын эзэнт улсын бүрэлдэхүүнд оржээ.

1871 онд Герман улс анх удаагаа нэгдэж, Германы эзэнт улсыг байгуулав. 1914 онд Дэлхийн I дайныг Герман улс эхлэв. 1919 онд Ваймарын бүгд найрамдах улс байгуулагдав. 1939 онд Герман улс дэлхийн II дайны дараа Германы баруун хэсэгт АНУ, Англи, Францын эзэмшил газарт 1949 оны 5 дугаар сарын 23-нд ХБНГУ байгуулагдаж, Зүүн хэсгийн ЗХУ-ын эзэмшил газарт 1949 оны 10 дугаар сарын 7-нд БНАГУ байгуулагдсан байна.

1990 оны 10 дугаар сарын 3-нд ардчилсан Герман улс албан ёсоор ХБНГУ-тай нэгдэж нэгдмэл Герман улс байгуулагдав.

ХБНГУ нь (The Federal Republic of Germany) 357022,17 км² газар нутагтай. 82,2 сая хүн амтай. /1999 оны эцсээр/ Тус улсад 7 сая 340 мянган гадаадын харъяат оршин суудаг нь хүн амын 9%-ийг эзэлдэг. Хүн амын 32,5% нь христосын шинэ шашны, 33,02% нь Ромын католик шашин шүтдэг. Нийслэл Берлин 3 сая 387 мянган хүн амтай.

Европын төв хэсэгт байрлах Герман улс нь зүүгээрээ Польш, Чех өмнүүрээ Австри, Швейцарь баруугаараа Голланд, Бельги, Люксембург, Франц хойгуураа Дани болоод Умарт тэнгис, Балтийн тэнгисийн усаар хүрээлэгддэг.

Германы дотоод улс төрийн амьдралд 2000 оноос харьцангуй их өөрчлөлт гарч нийгмийн ардчилсан нам, ногоонтны нам хамтран засгийн эрхэнд гарч, эдийн засаг, нийгмийн дорвитой шинэтгэл явуулах болов. Гол сөрөг нам Христосын ардчилсан холбоо түрүүчийн ерөнхий сайд /канцлер/ Г. Колийн улс төийн бодлогын хямралаас болж, удирдах бүрэлдэхүүнээ шинээр сольж сэлбэлээ.

ХБНГУ нь өндөр хөгжилтэй аж үйлдвэрийн орон бөгөөд эдийн засгийн хүчин чадлаараа Европт 1 дүгээр байрт олон улсын тавцанд Америк, Японы дараа гуравдагч том эдийн засгийн хүчирхэг улс бөгөөд АНУ-ын худалдааны хоёрдогч түнш юм.

2000 онд Германы эдийн засгийн өсөлт 3,1%-д хүрч 1991 оноос хойш хамгийн дээд хэмжээнд хүрэв. Улсын дотоодын үйлдвэрлэлийн нийт өртөг 1.942.400 тэрбум долларт хүрч нэг хүнд ноогдох хэмжээ дунджаар 23.606 ам доллар болжээ.

Герман нь чулуун нүүрс, хүрэн нүүрс, давснаас бусад байгалийн баялагаар харьцангуй ядуу орны нэг бөгөөд энэ талаар импортод голлон түшиглэдэг. Чулуун нүүрсний нөөц нь 230.000 тэрбум тн ашиглан болох нөөц нь 24 мянган тэрбум тн бөгөөд илрүүлээд байгаа нефть 50 сая тн, байгалийн хий 5 сая тэрбум м³.

1999 оны байдлаар улсын төсвийн 10,2% нь батлан хамгаалах зардал байсан нь дотоодын нийт бүтээгдэхүүний 1,2% болж байв. НАТО-гийн Германд суугаа цэрэг АНУ-ынх 68820, Английнх 18300, Францынх 3300, Голландынх 3000, Бельгийнх 2100 хүн байдаг. Германы арми 332800 хүнтэй.

ХБНГУ-ын үндэсний орлогын нэг хүнд ноогдох хэмжээ 34900 марк бөгөөд баруун хэсгийн дундаж амьдралтай 100 айл тутамд 144,5 автомашин, 136,4 телефон утас, 188,1 телевиз, 109,9 магнитофон, 91,5 компьютер, 103 хөргөгч ногддог байна. Зүүн хэсэгтээ дунд зэргийн орлоготой 100 айл тутамд 159,2 автомашин, 113,8 телефон утас, 89,3 телевиз, 108,1 магнитофон, 90,1 компьютер, 99 хөргөгч ноогддог ажээ.

Герман бол хэвлэл мэдээлэл, хэвлэлийн газар ихэд хөгжсөн орон. 1999 онд 367 төрлийн өдөр тутмын сонин, 1620 орон нутгийн сонинг 380 хэвлэлийн газар, 135 хэвлэлийн товчоогоор 250 тэрбум хувиар тараасан байна. Нэг хүнд ноогдох сонин хэмжээгээр Япон, Англи, Швейцарийн дараа ордог. 1600 гаруй төрлийн сэтгүүл, 8000 гаруй төрлийн тусгай хэвлэл хэвлэгдэн гардаг.

Шар айраг буюу пиво бол герман хүн бүрийн уух дуртай ундаа төдийгүй “шингэн талх” хэмээн хүндэтгэн дээдэлдэг идээ.

Германчууд зөвхөн пиво уухад жил бүр 20 тэрбум дойч марк зарцуулдаг ба нэг хүнд дунджаар 300 шил буюу 150 л ноогддог. Энэ тоо өдгөө ч өссөөр байгаа бөгөөд үүгээрээ тус орон дэлхийд тэргүүлдэг. Иймээс ч Герман улс “пивоны орон” гэж алдаршжээ. Германчууд пиво хэдэн зуун жилийн тэртээгээс ууж заншсан юм. Тэртээ 1040 онд Мюнхений нэгэн дүүргийн Кербени хэмээгч шашин дэлгэрүүлэгч эр пиво үйлдвэрлэх технологи нээснээр уг дүүрэг пивоны өлгий нутаг гэгдэж, хожим тэнд пивоны их сургууль байгуулагджээ.

Хоёр Герман нэгдэхээс өмнө зөвхөн ХБНГУ-д 1350 пивоны үйлдвэрт 5000 гаруй төрлийн пиво үйлдвэрлэж, дэлхийн 120 гаруй улс оронд борлуулдаг байлаа.

Түүнчлэн Германы пивочдын нам улс төрийн амьдралд оролцож, парламентанд суудал авахын төлөө тэмцдэг явдал бий.